



**ДУНДГОВЬ АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ**

2018 оны 05 сарын 24 өдөр

Дугаар 05

Мандалговь

Хөрөнгө бүртгэлд авах тухай

Монгол улсын "Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль"-ийн 77 дугаар зүйлийн 77.2.3, 77.3 дахь заалт, аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2014 оны 232 дугаар тогтоолоор батлагдсан "Орон нутгийн өмчит хуулийн этгээдийн эд хөрөнгийн харилцааг зохицуулах журам"-ын 2 дугаар зүйлийн 2.1 дэхь заалтыг тус тус үндэслэн Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдээс **ТОГТООХ НЬ:**

1 Сайнцагаан сумын Засаг даргын тамгын газрын өөрийн хөрөнгөөр бэлтгэсэн 15,000,000 /арван таван сая/ төгрөгний үнэ бүхий Приус30 маркын суудлын автомашиныг данс бүртгэлдээ бүртгэж авахыг зөвшөөрсүгэй.

2. Шинээр бэлтгэсэн эд хөрөнгийг холбогдох хууль тогтоомжийн дагуу байгууллагын данс бүртгэлд бүртгэж авахыг Сайнцагаан сумын Засаг даргын тамгын газрын дарга /Б.Оюунчимэг/-т даалгасугай.

3. Тогтоолын хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг Орон нутгийн өмчийн газрын дарга С.Ууганбаярт үүрэг болгосугай.

ДАРГА  С.СҮХБААТАР